



ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ЗӨВЛӨЛ

ӨМНӨД АЗИ ДАХЬ ТЕРРОРИЗМЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

ТТЗ-ИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
2020-8



ТАНИЛЦУУЛГА

ӨМНӨД АЗИ ДАХЬ ТЕРРОРИЗМЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Өмнөд Азийн бүс нутагт Афганистан, Бангладеш, Бутан, Энэтхэг, Мальдив, Мьянмар, Непал, Пакистан, Шри Ланка зэрэг улс орших бөгөөд эдгээр орнуудын дотоодын улс төр, эдийн засгийн тогтворгүй байдал, иргэний дайн, үндэстэн болон шашин хоорондын зөрчил мөргөлдөөн, хэт даврах болон салан тусгаарлах үзэлтэй бүлэг, этгээдүүд, хөрш улсуудын газар нутгийн маргаан зэргээс үүдэн тус бүс нутаг дахь терроризмын эрсдэл өндөр байна. Түүнчлэн Аль-Кайда, Исламын Улс зэрэг олон улсын террорист байгууллагууд өмнөд ази дахь исламын шашинт иргэд, хэт даврах үзэлтэй бүлэглэлүүдтэй холбоо тогтоон суртал ухуулга явуулах, элсүүлэх, террорист халдлага зохион байгуулах үйл ажиллагаа явуулж байна. 2020 оны эхний хагас жилийн байдлаар тус бүс нутагт 7000 гаруй хүн террорист халдлагын улмаас амь насаа алджээ.

Бүс нутгийн терроризмын нөхцөл байдал

Афганистан:



Афганистан Улс дахь терроризмоос үүдэлтэй хүчирхийллийн нөхцөл байдал хүндэрч, талибанчуудын¹ үйлдсэн халдлагад цэргийн албан хаагчид, энгийн иргэд өртөж амь эрстэх явдал нэмэгдэж байна. Хэдийгээр 2020 оны 3 дугаар сард АНУ, Афганистанын Засгийн газар болон Талибаны талууд гал зогсоох хэлэлцээрт гарын үсэг зурж 20 жилийн турш үргэлжилсэн зэвсэгт мөргөлдөөнийг зогсоох арга хэмжээг авч эхэлсэн ч 5000 орчим талибан хоригдлыг сулласны дараагаар уг хэлэлцээрийг хэрэгжүүлж эхлэх байр суурьтай

байгааг Талибан хөдөлгөөний удирдлагууд мэдэгдэж байна.

Афганистан болон Пакистаны хил орчмын байршил Талибан хөдөлгөөн болон Хаккани бүлэглэлийн² үйл ажиллагаа явуулах аюулгүй, таатай орчин болж байгаа бөгөөд Пакистаны талын дэмжлэгтэйгээр АНУ-ын тэргүүлсэн НАТО-ын цэргийн хүчин, Афганистаны зэвсэгт хүчин, хууль сахиулах байгууллага, НҮБ-ын ажилчид руу чиглэсэн халдлага үйлдсээр байна. Түүнчлэн уг бүс нутаг дахь эдгээр бүлэглэлүүд тогтвортой үйл ажиллагаа явуулж, Аль-Кайда³ террорист байгууллагатай хамтран ажиллаж буй нь Европ дахь терроризмын нөхцөл байдалд сөргөөр нөлөөлж байна хэмээн зарим улс орнууд үзэж байна.

Бангладеш:



Бангладеш дахь терроризмын нөхцөл байдал 2020 онд харьцангуй тайван, тогтвортой байгаа бөгөөд 2009 оноос исламын терроризм, экстремизмтэй тууштай тэмцэж буй орон юм.

Аль Кайда, Жамаат эл Мужахидин Бангладеш⁴ зэрэг террорист байгууллагатай холбоотой этгээдүүдийг илрүүлэх, террорист халдлагаас урьдчилан сэргийлэх ажлыг тус улсын тусгай алба, хууль сахиулах байгууллага тогтмол зохион байгуулж байна. Эдгээр террорист байгууллагууд цахим олон нийтийн сүлжээг ашиглан үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилт татахын зэрэгцээ Бангладеш Улсын алслагдмал нутагт амьдарч буй исламын шашинт залуучууд руу чиглэсэн суртал ухуулгын шинж чанартай ажиллагааг Facebook, WhatsApp, Telegram зэргийг ашиглан хэрэгжүүлж байна.

Тус улсын иргэдийн 90 гаруй хувь нь исламын шашин шүтдэг бөгөөд цөөнх хинду шашинт иргэдийг ялгаварлан гадуурхах, сүм хийдэд халдлага үйлдэх зэрэг хэрэг явдал гарч байна. Түүнчлэн Хизб ут Тахрир Бангладеш⁵ террорист байгууллага Палестин болон Энэтхэгийн Жамму Кашмир мужийн “ариун” газрыг еврей, хинду нараас чөлөөлөх тэмцэлд исламын шашинт улс орнуудыг уриалсан тухай мэдэгдлийг олон нийтийн сүлжээгээр тарааж байна.

Бутан:



Бутан Улсын хөрш улс Энэтхэгээс салан тусгаарлах үзэлтэй зэвсэгт бүлэглэлүүд тус улсын нутаг дэвсгэрийн өмнөд хэсэгт хил даван орогнох явдал гарч байсан ч Бутаны Засгийн газраас терроризмтой тэмцэх арга хэмжээг идэвхтэй явуулж, хилийн бүс, зурваст тавих хяналтыг сайжруулах, террорист бүлэглэлүүдийг өөрийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэхгүй байх арга хэмжээг авсан ба үүний үр дүнд тус улсын нутаг дэвсгэрт эдгээр бүлэглэлүүдийн үйл ажиллагаа бүрэн зогсож, терроризмын аюул занал харьцангуй бага түвшинд байна.

¹ 1996-2001 оны хооронд Афганистаны засгийн эрхийг барьж байсан бөгөөд 2001 онд АНУ болон түүний холбоотны цэргийн хүчин Афганистанд орж ирснээр Талибанчууд Афганистан дахь эрх мэдлээ алдсан юм. Тиймээс Талибанчууд АНУ-ын цэргийн хүчнийг Афганистаны нутаг дэвсгэрээс хөөх, одоогийн Засгийн газрыг түлхэн унагах тэмцлийг эхлүүлсэн.

² 1970-аад оны үед бий болсон террорист байгууллага бөгөөд Аль-Кайда, Талибанчуудын нөлөө бүхий холбоотон юм. АНУ-ын тэргүүлсэн НАТО-ын цэргийн хүчин болон одоогийн Афганистаны Засгийн газрын эсрэг олон удаагийн террорист халдлага үйлдсэн.

³ 1979-1989 онд өрнөсөн Афганистан дахь ЗХУ-ын явуулсан цэргийн ажиллагааг эсэргүүцэж бий болсон исламын террорист байгууллага бөгөөд улмаар исламын шашинт улс орнуудад явуулж буй АНУ зэрэг барууны орнуудын үйл ажиллагааг эсэргүүцэж томоохон хэмжээний террорист халдлага үйлдсэн.

⁴ Бангладеш Улсад үйл ажиллагаа явуулдаг террорист байгууллага бөгөөд Шариатын хуульд үндэслэн исламын улсыг байгуулж одоогийн засгийн газрыг түлхэн унагах зорилготой юм.

⁵ Бангладешийн эрх баригч хүчний эсрэг хэд хэдэн удаа халдлага үйлдсэн бөгөөд тус бүлэглэлийг Бангладешийн Засгийн газраас террорист бүлэглэл хэмээн зарлаж, үйл ажиллагааг нь хориглосон юм.

Энэтхэг:



Энэтхэг Улсын Жамму Кашмир мужийн хүн амын дийлэнх нь исламын шашинт иргэд бөгөөд цорын ганц исламын шашин голлосон муж юм. Уг мужид олон жилийн турш шашны болоод улс төрийн шалтгаанаар Энэтхэгийн засаг захиргааг эсэргүүцсэн салан тусгаарлах үзэлтэй бүлэглэлүүд оршсоор ирсэн. Хизбул Мужахидин, Жаиш э Мохаммед⁶ болон бусад террорист бүлэглэлийн гишүүд сайн дурын хүмүүнлэгийн ажил хийх халхавч дор хүүхэд залуусыг радикалчлалд уриалан дуудах, Засгийн газрын эсрэг тэмцэлд нэгдэхийг турхирах, хууль хүчний байгууллага руу чиглэсэн халдлага үйлдэх явдал гарч байна. Харин тус улсын Засгийн газраас Жамму Кашмир мужид үйл ажиллагаа явуулж буй эдгээр террорист бүлэглэлтэй тэмцэх үйл ажиллагааны хүрээнд террорист этгээдүүдийг устгах, баривчлах арга хэмжээг идэвхтэй өрнүүлж байна.

Аль Кайда, Тэхрик ул Мужахидин⁷ зэрэг террорист бүлэглэлүүд Жамму Кашмир дахь энэтхэгийн захиргаа болон тэднийг дэмжигчдийг заналхийлсэн агуулгатай анхааруулга, суртал ухуулгын материалыг цахим орчин дахь мэдээллийн сувгуудаар дамжуулан тараах явдал гарч байна.

Түүнчлэн Энэтхэг Улсын Панжаб мужид Калистаны салан тусгаарлах хөдөлгөөнийг⁸ дэмжигч террорист этгээдүүдийн үйл ажиллагаа идэвхжиж байгаатай холбогдуулан тус улсын Үндэсний мөрдөн шалгах газраас⁹ Калистаны салан тусгаарлах хөдөлгөөнийг гадаад болон дотоодын эх үүсвэрээс санхүүжүүлсэн гэх үндэслэлээр хэд хэдэн сикх¹⁰ иргэдийг баривчилжээ.

Террорист этгээдүүд нисгэгчгүй нисэх аппарат ашиглан Энэтхэг, Пакистаны хилээр галт зэвсэг, хуурамч мөнгөн дэвсгэрт зэрэг террорист халдлага үйлдэхэд шаардлагатай эд зүйлийг хууль бусаар нэвтрүүлэх явдалтай Энэтхэгийн Хилийн аюулгүй байдлыг хангах хүчин болон холбогдох байгууллагууд тэмцээр байна.

Энэтхэгийн тал дээрх террорист байгууллагуудын үйл ажиллагаанд Пакистан Улсаас санхүүжүүлэх, сургах, зэвсэг техникээр хангах зэрэг бүхий л талаар дэмжлэг, туслалцаа үзүүлж байна хэмээн буруутгаж байна.

Мальдив:



Мальдив Улсад 2017 оноос хойш террорист халдлага гараагүй ч шашны хэт даврах үзэлт бүлэглэлүүд христийн шашныг дэлгэрүүлэх, исламын шашны эсрэг үйлдэл хийсэн зэрэг үндэслэлээр зарим хүний эрхийн байгууллага руу чиглэсэн заналхийлэл, олон нийтэд эдгээр байгууллагуудын талаар сөрөг ойлголт төрүүлэхүйц суртал ухуулга явуулах зэрэг шашны хэт даврах үзэлтэй холбоотой хэрэг явдал гарч байна. Тиймээс Исламын Улс, Аль Кайда зэрэг террорист байгууллагын зүгээс тус улсын иргэдийг элсүүлэх, цаашлаад

Мальдив Улсад террорист халдлага үйлдэх нөхцөл байдал үүсч болзошгүй байна.

Мьянмар:



Мьянмар Улсын Засгийн газраас үндэстний цөөнх исламын шашинт рохинжа иргэдийн талаар хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрийг эсэргүүцсэн дотоодын террорист бүлэглэл Аракань арми¹¹ эмх замбараагүй байдал үүсгэх, Засгийн газрын болон зэвсэгт хүчний албан хаагчид, тэдгээрийн гэр бүл рүү чиглэсэн халдлага үйлдэж байна. 2017 онд тус улсын Засгийн газраас Аракань армийг террорист бүлэглэл хэмээн зарласан бөгөөд хоёр талын мөргөлдөөний улмаас олон мянган Рохинжа иргэд Бангладеш зэрэг исламын шашинт хөрш улсууд руу дүрвэх явдал идэвхжиж байна.

Түүнчлэн Мьянмар Улсын Карен муж, Шан мужид байрлах салан тусгаарлах үзэлтэй бүлэглэлүүд хар тамхи, зэвсгийн наймаа хийх зэргээр санхүүжилтийн эх үүсвэрээ бүрдүүлж байна. Карены үндэсний чөлөөлөх арми, Шан мужийн арми зэрэг салан тусгаарлагч бүлэглэлүүдийн хууль бус наймааг зогсоох тэмцлийг Засгийн газраас эрчимжүүлж, нийт 1 тэрбум орчим ам.долларын үнэ бүхий мансууруулах бодис, зэр зэвсгийг хураажээ.

Тус улсын Засгийн газар болон бусад террорист бүлэглэлүүд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим орчинг ашиглан харилцан суртал ухуулга хийх явдал гарч байгаа бөгөөд үзэн ядах үг хэллэг, экстремизмтэй тэмцэх зорилгоор зарим хотод интернетийн хэрэглээг урт хугацааны турш хязгаарлах арга хэмжээ авч байгаад зарим улс орнууд шүүмжлэлтэй байр суурьтай байна.

Непал:



Непал Улсад дотоодын улс төрийн намуудын зөрчлөөс үүдэлтэй үймээн самуун, эмх замбараагүй байдал гарахын зэрэгцээ дэд бүтэц, засгийн газрын байр руу халдах явдал гарч байна. Тус улсын засгийн газраас Непалын коммунист намын Нитра Бикрам Чандын фракцыг /Биплав/ хэд хэдэн удаагийн халдлагад буруутгаж байна. Олон улсын террорист байгууллагуудаас Непал Улс руу чиглэсэн террорист халдлага үйлдэх аюул занал харьцангуй бага боловч гадаадын террорист

⁶ Хизбул Мужахидин, Жаиш э Мохаммед бүлэглэл нь Пакистан Улсад орогнох террорист бүлэглэл бөгөөд Кашмирын бүс нутгийг Пакистан Улсад нэгтгэх зорилготой.

⁷ Энэтхэгийн Жамму Кашмир мужийг Пакистантай нэгтгэх зорилготой салан тусгаарлах үзэлт бүлэглэл.

⁸ Панжабын бүс нутагт Сикхчүүдийн тусгаар улс Калистан Улсыг байгуулах зорилготой хөдөлгөөн.

⁹ БНЭУ-ын терроризмтой тэмцэх чиг үүрэгтэй хууль сахиулах байгууллага.

¹⁰ Энэтхэгийн Панжаб мужид оршин суух Сихийн шашинт иргэд бөгөөд тус мужид 20 гаруй сая иргэд Сихийн шашин, соёлыг баримтлан амьдарч байна.

¹¹ Мьянмар болон Малайз Улсын Засгийн газраас тус бүлэглэлийг террорист бүлэглэл хэмээн зарласан.

дайчид дамжин өнгөрөх, террорист бүлэглэлүүд орогнох зэрэг эрсдэл байж болзошгүй хэмээн Засгийн газраас үзэж байна.

Пакистан :



Салан тусгаарлах үзэлтэй Балочистанын чөлөөлөх арми¹², Синдийн хувьсгалт арми¹³ зэрэг бүлэглэлүүд Пакистанд үйлдэгдсэн хэд хэдэн террорист халдлагыг балочистан болон синди иргэдийн эсрэг авч хэрэгжүүлж буй засгийн газрын шийдвэрийг эсэргүүцэж үйлдсэн болохоо зарласан юм. Түүнчлэн Пакистан дахь Талибан хөдөлгөөний зүгээс гадаадын иргэд, хууль сахиулах, цэргийн албан хаагчид рүү чиглэсэн хэд хэдэн удаагийн халдлага зохион байгуулав.

Тус улсын улс төрийн нөхцөл байдал тогтворгүй байгаа бөгөөд ковид-19 цар тахлын үед Засгийн газраас гаргаж буй шийдвэрүүдэд иргэд бухимдаж, эрх баригч хүчний нэр хүнд ихээхэн унаж байна. Түүнчлэн Пакистаны Засгийн газрыг Афганы Талибан, Лашкар э Тайба¹⁴, Жаиш э Мухаммэд¹⁵ зэрэг Афганистан, Энэтхэгийн эсрэг террорист үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, өөрийн улсад орогнох, терроризмыг санхүүжүүлэх, цахим орчин дахь суртал ухуулга хийх явдлын эсрэг идэвхтэй тэмцэхгүй байна хэмээн олон улсын зүгээс шүүмжилж байна. 2018 онд Пакистан Улс нь Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллагын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтад /саарал жагсаалт/ орсон бөгөөд илэрсэн дутагдлыг арилгахад зарим ахиц дэвшил гарсан хэдий ч хангалттай хэмжээнд хүрч ажиллахгүй байгааг анхааруулав.

Пакистаны Синд, Панжаб мужид амьдрах шашны цөөнх иргэдийн амь нас, эд хөрөнгөнд халдах, исламын шашны номлолыг хүчээр тулгах, сүм хийд, хөшөөг нураах зэрэг исламын хэт даврах үзэлтэй иргэдийн үйлдэл идэвхжих хандлагатай байна.

Шри Ланка:



2019 онд Шри Ланкын исламын террорист байгууллагууд Исламын Улс террорист байгууллагатай хамтран улаан өндөгний баярын үеэр христийн сүм, томоохон зочид буудлууд руу террорист халдлага үйлдэж 260 гаруй хүн амь насаа алдсан юм. Уг явдлын дараа исламын шашны эсрэг хөдөлгөөн өрнөж буддын болон христийн шашинт иргэд исламын шашинт иргэдийн амь нас, эд хөрөнгөнд халдах, сүм хийдийг сүйтгэх зэргээр эмх замбараагүй байдал үүссэн. Түүнчлэн үндэстний цөөнх тамил

иргэд Засгийн газрын гаргаж буй шийдвэрүүд нь тамил¹⁶ иргэдийн эрх ашгийг хөндсөн хэмээн үзэж удаа дараа дургүйцлээ илэрхийлэв. Тиймээс тус улсын Засгийн газраас дахин террорист халдлага үйлдэгдэх, шашин хоорондын мөргөлдөөн, эмх замбараагүй байдал гарахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чадавхыг сайжруулах зорилгоор НҮБ, АНУ болон Япон зэрэг улсуудтай нягт хамтран ажиллаж байна.

ДҮГНЭЛТ: Өмнөд Ази дахь терроризмын нөхцөл байдал тогтворгүй, эрсдэл өндөр байгаатай холбоотойгоор тус бүс нутгаас Европын Холбоо болон бусад улс руу чиглэсэн цагаачдын урсгал нэмэгдэх хандлагатай байна.

Хэдийгээр тус бүс нутгийн улс орнууд терроризмтой тэмцэх чиглэлээр идэвхтэй ажиллаж байгаа ч терроризм үл нутагших, террорист этгээд орогнохгүй байх нөхцөлийг бүрдүүлэхэд гадаад болон дотоод хүчин зүйлс ихээхэн саад учруулж байна. Тухайлбал, Өмнөд Азийн улсуудын иргэдийн шашин шүтлэг, ёс суртахуун, үндэстэн ястны ялгаатай байдал, үндэстний болоод шашны цөөнхийн эсрэг авч хэрэгжүүлж буй төр, засгийн бодлого, олон нийтийн хандлага зэрэг нь нэгнээ үзэн ядах, радикалчлал, хэт даврах үзэлд автах нөхцөлийг бүрдүүлэх нь дотоод хүчин зүйл болж байна. Түүнчлэн тус бүс нутаг дахь улс орнуудын хоорондын хил хязгаар, газар нутгийн маргаан зэрэг ашиг сонирхолын зөрчлөөс үүдэж хөрш зэргэлдээ улсууд дахь салан тусгаарлах үзэлт бүлэглэлүүдийн үйл ажиллагааг дэмжих, шашны цөөнхийг хүчирхийлэлд өдөөн турхирах зэргээр тухайн улсын дотоодын нөхцөл байдлыг дэвэргэх явдал гарч байгаа нь гадаад хүчин зүйл болж байна.

Иймд террорист бүлэглэлийн зүгээс уг эмзэг цэгийг онилж, цахим орчинд тухайн улсын төр засаг, исламын бус шашинт иргэдийн эсрэг чиглэсэн суртал ухуулгыг тараах, террорист байгууллагад элсүүлэх, цахим валют ашиглан хандив, санхүүжилт босгох үйлдлүүд идэвхжиж байна. Тиймээс манай улсын хувьд тус бүс нутгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, тэдгээр террорист байгууллагын цахим орчинд явуулж буй суртал ухуулга, өдөөн хатгалга, терроризмыг санхүүжүүлэх эх үүсвэр бий болгох аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр анхаарал хандуулж, энэ төрлийн үйлдлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА

¹² Пакистан Улсаас салан тусгаарлаж, Балочистаны тусгаар улс байгуулах зорилготой байгууллага.

¹³ Пакистан Улсаас салан тусгаарлаж, Синдийн тусгаар улс байгуулах зорилготой байгууллага.

¹⁴ Энэтхэг Улсад үйлдэгдсэн томоохон террорист халдлагуудыг зохион байгуулсан гэх ба АНУ, Энэтхэг, Израилийг исламын шашны эсрэг дайсан хэмээн зарлаж, нэгэн цагт мусульманчуудын эрхшээлд байсан газар нутгийг буруу номтнуудаас буцаан авах хүртэл тэмцэх болно хэмээн зарласан.

¹⁵ Кашмир бүс нутгийг Пакистан Улсад нэгтгэх зорилготой бүлэглэл.

¹⁶ Шри Ланка Улсын нийт хүн амын 11 хувийг эзэлдэг Хинду шашинт иргэд.